Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны .... сарын ..... -ны өдрийн ......... бичгийн ......... хавсралт

# Алсын хараа – 2050

## Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

## "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ

## /2023 оны жилийн эцэс/

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь / Дээд шатны байгууллагын үнэлгээ, тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ес. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ | | | |
| 21 | 9.1. Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно. | 9.1.19. Байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх орчныг бүрэн хангана. | 2020 - 2050 | - | налуу зам нэмэлтээр хийнэ | • Байгууллагын гадна шатанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам нэмэлтээр хийсэн. | 100 |
| 71 | 9.3. Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө. | 9.3.7. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | - | 100 айл орчмын барилгын материалын үйлдвэрүүдийг шилжүүлэх ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу ажиллах. | • Паркийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ханын материалын үйлдвэрлэлийн бүс болон жижиг дунд үйлдвэрлэлийн бүсийг хамруулан 13 га газарт дэд бүтцийн шугам сүлжээ, зам талбайд тохируулан 0,05га /500м2/ эдэлбэр газар бүхий 126 аж ахуйн нэгжийн төлөвлөгөө боловсруулсан ба 2023 оны байдлаар 3 аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулаад байна.<br>• 100 айлын барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаа хийгдсэн ба эхний ээлжийн 26 аж ахуйн нэгж болох мод, чулуу, дээврийн төмөр, вакум цонхны үйлдвэрлэл эрхлэгчдийн нэрсийг гаргасан. Мөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг барилгын материалын зах, бөөний төвүүдийн судалгааг хийсэн. | 100 |
| 132 | 9.5. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн | 9.5.1. Дагуул, хаяа хот, тосгоныг тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр | 2020 - 2050 | - | НБМҮТП-ийн дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ. | • 2х16 мВА чадалтай 110/10 кВ-ын "Налайх парк" дэд станцын барилга угсралт, монтажийн ажил дууссан ба 110, 10 кВ-ын шугам сүлжээнд холбох холболт, туршилт тохируулгын ажил үлдээд байна. 110 кВ-ын ЦДАШ-ын угсралтын ажил эхлээгүй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ. | төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна. | | | | бөгөөд 4 ширхэг хаалттай хуваарилах байгууламжийн барилга угсралт, кабель шугамын суваг шуудууны ажлууд хийгдсэн. Уг ажил 20%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд энэ онд үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх, үлдэгдэл санхүүжилт 6,208,000,000 төгрөгийг нийслэлийн 2024 оны төсөвт баталуулсан. Дээрх төсөл арга хэмжээ 2024 онд бүрэн дуусаж ашиглалтанд хүлээж авна.<br>• Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй “Тэгшт плант” ХХК нь үйлдвэрийн зориултай 2га газрыг мөн “Ногоон цагираг” ХХК 2,76 га газрыг хашаалж үйлдвэрээ паркт нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлсэн.<br>• Парк нь өөрийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоогийн байдлаар 250 га газарт нийт 52 аж ахуй нэгжтэй үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар 24 аж ахуйн нэгжтэй гэрээ дүгнэн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, бичиг баримт, зураг төслийн бүрдлийг хангах шаардлага хүргүүлсэн бөгөөд 9 аж ахуй нэгжтэй гэрээ цуцалсан. 10 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулах газарт хашаа барин үйлдвэрийн барилга байгууламжаа барих бэлтгэл ажлыг хангаад байна. 5 аж ахуй нэгж бичиг баримтын бүрдэл хангагдан үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн бөгөөд барилга угсралтын ажил 80%-тай явагдаж байна. 5 аж ахуйн нэгжид үйлдвэрийн бүтээн байгуулалтад шаардлагатай цахилгаан хангамжийн түр тэжээлээр хангаад байна.<br>• 2019.02.15-ны өдрөөс хаягдал хөнгөн цагаан, хайлшыг дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэн 95 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна. Уг үйлдвэр нь 2023 онд 138,091 ш бүтээгдэхүүн үйлдвэрлэж 135,300 ш бүтээгдэхүүнийг экспортод гаргасан.<br>• Паркт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн ажиллах хүчний хэрэгцээний судалгааг гаргаж, сул орон тоо гарсан даруй Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст мэдээлэл хүргүүлэн, Налайх дүүргийн ажилгүй иргэдийг ажлын байраар ханган ажиллаж | |
| 134 | | 9.5.5. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгээр дагуул хотуудад шилжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана. | 2021 - 2030 | | | | |
| 138 | | 9.5.9. Аж үйлдвэрийн бүсүүдийг салбар чиглэл бүрд төлөвлөн, кластер байдлаар дагуул хотуудыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татахын тулд үйлдвэр технологийн паркуудын газрыг худалдах, түрээслэх замаар эзэмшүүлнэ. | 2021 - 2030 | | | | |
| 139 | | 9.5.10. Улаанбаатар хотын бүсийн хэмжээнд өндөр технологийн үйлдвэрүүдийг нутагшуулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулна. | 2021 - 2030 | | | | |
| | | | | | | | |
| 145 | | 9.5.16. Өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ. | 2021 - 2030 | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. одоогоор Налайх дүүргийн 95 иргэнийг тогтмол ажлын байраар хангаад байна.<br>• “Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төв” байгуулах төслийг НБМҮТП-г түшиглэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах Тогтоол, захирамжийн хүрээнд 60 га талбайд Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хөрөнгө оруулалтын санал болон зураг төсөл гүйцэтгүүлэх саналыг НЗДТГ-т хүргүүлсэн.<br>• “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийг усаар хангах усан хангамжийн байгууламж, усан сан, гүний худгийн барилга байгууламж, шугам хоолойн угсралтын ажлын бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлын хүрээнд паркийн 120 га газар дээр байгуулах 2 ширхэг гүний худгийн өрөмдлөгийн ажил хийгдэж дууссан. 2 худгийн барилгын ажил хийгдэж байна. “ТТТ” ХХК-руу татах 6.3 км шугам хоолойн газар шорооны ажил бүрэн дууссан. Улсын комисс ажилсан.<br>• Барилга, хот байгуулалтын сайдын 2020.09.07-ны өдрийн 169 дугаар тушаалын дагуу паркийн өргөтөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт явагдаж 228.8 сая төгрөгөөр “Өрх” ХХК 2021.01.28-ны өдөр 2021/47 дугаар гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл дууссан ба мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт хийгдэж байна. |

ЗӨВШӨӨРСӨН:

НБМҮТП ОНӨТҮГ-ЫН ДАРГА С.БАТЖАРГАЛ

ХЯНАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Н.ПҮРЭВСҮРЭН

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Х.БЯМБАА

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ТТБ8651 ... 5890683